



Хэвлэлийн мэдээ
2016 оны 6-р сарын 15-ны өдөр, Лхагва гараг

Холбогдох утас:
9710-9009

Монгол дахь Америкийн Худалдааны Танхим
АНУ-ын Элчин Сайдын Яамтай Хамтран Агро Бизнесийн Боломжийг
Судлах АНУ-ын Худалдааны Төлөөлөгчидтэй Дугуй Ширээний Уулзалтыг
Зохион Байгууллаа

2016 оны 6-р сарын 13-нд Монгол дахь Америкийн Худалдааны танхим (АмЧам) нь Дугуй ширээний уулзалтыг Монгол дахь АНУ-ын Элчин Сайдын Яам, АНУ-ын Худалдааны Яам болон АНУ-ын Худалдааны Яамны Хятад, Монголын асуудал хариуцсан Дэд сайдын орлогч Патрик Сантилло болон Бээжин дэх АНУ-ын ХАА-н яамны Амьтан, ургамлын эрүүл ахуй хорио цээрийн албаны Ази номхон далайн асуудал хариуцсан Бүсийн менежер Др. Мурали Бандлагаар ахлуулсан Агро Бизнесийн Боломжийг Судлах АНУ-ын Худалдааны Төлөөлөгчидтэй хамтран зохион байгууллаа.

Уулзалтанд Монгол улсын Хөдөө аж ахуйн салбарын тэргүүний төлөөлөгчид, олон улсын болон дотоодын банк, санхүүгийн байгууллагууд, төрийн бус байгууллагууд, АНУ-ын Элчин Сайдын Яам болон АмЧамын гишүүдээс бүрдсэн 30 гаруй төлөөлөгчид оролцож Монголын хөдөө аж ахуйн салбарын санхүүжилт, бизнесийн боломж болон шийдлийн талаар дэлгэрэнгүй хэлэлцсэн юм.

Агро Бизнесийн Боломжийг Судлах АНУ-ын Худалдааны Төлөөлөгчид нь Монголын хөдөө аж ахуйн салбар тэр дундаа тоног төхөөрөмж, техник технологи, үйлчилгээ болон сүү сүүн бүтээгдэхүүн, газар тариалан, мах махан бүтээгдэхүүн болон арьс шир зэрэг бүтээгдэхүүнүүдийг судлан танилцахаар айлчлаад байгаа юм.

АНУ-ын Худалдааны Яамны Хятад, Монголын асуудал хариуцсан Дэд сайдын орлогч Патрик Сантилло уулзалтын үеэр өгсөн ярилцлагандаа Ил тод байдлын тухай гэрээ ач холбогдлыг онцлон тэмдэглэж “Ил тод байдлын тухай гэрээг бүрэн дүүрэн хэрэгжүүлэх нь Америкийн болон олон улсын бусад компаниудыг Монгол улсад хөрөнгө оруулахыг дэмжих өндөр ач холбогдолтой” гэв.

“Монгол дахь Америкийн Элчин Сайдын Яам нь хөдөө аж ахуйн салбарын хөгжлийг дэмжих олон арга хэмжээнүүдийг АмЧам Монгол болон бусад бизнесийн байгууллагуудтай хамтран зохион байгуулдаг” хэмээн Монгол дахь АНУ-ын Элчин Сайдын Яамны Худалдааны Ахлах мэргэжилтэн ноён Майкл Ричмонд уулзалтын үеэр хэлэв.

АмЧам Монголын тухай

АмЧам Монгол нь АНУ-Монгол Улс хоорондын бизнесийн түншлэлийг өргөжүүлэх, бэхжүүлэх, эрх ашгийг нь хамгаалах болон Америкийн хөрөнгө оруулалтыг Монголд татах чиглэлээр ажилладаг бие даасан, гишүүддээ үйлчлэх төрийн бус байгууллага юм. АмЧам Монгол нь 3 сая гаруй гишүүдтэй дэлхийн хамгийн том бизнесийн холбоонд тооцогддог Америкийн Худалдааны Танхимын албан ёсны салбар юм. Мөн АмЧам Монгол нь Ази Номхон далайн 29 орнуудын Америкийн худалдааны танхимуудыг нэгтгэдэг Ази Номхон далайн орнуудын Америкийн Худалдааны Танхимуудын Зөвлөл байгууллагын гишүүн юм.